



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/188

Булган

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр дэх “Амжилтын галт тэрэг” дэд хөтөлбөрийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багшийн хөгжлийн төвийн тоо, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах зорилгоор Булган сумын Ерөнхий боловсролын лаборатори “Эрдмийн өргөө” цогцолбор сургуульд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 5 000 000 /таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



20190187